

# ДЭЛГЭРЦОГТ СУМЫН НУТГИЙН БАЙГАЛЬ УУЛ УСНЫ ТАЛААР


**Д**элгэрцогт сум элсэнцэр хүрэн хөрс бүхий талархаг гадаргатай, энэ нутагт хээрийн бүсийн монгол ургамал зонхилсон бэлчээртэй, чулуун нүүрс, утаат болор зэрэг ашигт малтмалын нөөц их байдаг. Халтарын уул, Цахирын уулнаас гадна далайн түвшнээс дээш 1456 метрийн өндөрт өргөгдсөн “Бага газрын чулуу”-ны үзэсгэлэнт сайхан уул нь аргаль, янгир, үнэг, хярс, тарвага зэрэг ан амьтантай, төрөл бүрийн ургамлаар баян сайхан хангай билээ.

## Бага газрын чулууны уул

Бага газрын чулууны ууланд 20 гаруй зүйлийн бутлаг, модлог ургамал, 300 орчим төрлийн эмийн ургамал ургадаг төдийгүй 100 гаруй төрөл зүйлийн шувуу, тарвага, туулай, үнэг, чоно, аргаль янгир, хэвлээр явагч амьтад байдаг. Мөн энд Хүннүгийн 3000 гаруй, хүрлийн үеийн болон Түрэгийн үеийн булш хиргисүүрүүд,

түүнчлэн хадны сүг зургууд элбэг бөгөөд усан, утаат, ягаан болорын олдоц их бий. Дундговь аймгийн тусгай хамгаалалттай Бага газрын чулууны ууланд түүх, соёлын дурсгалт газрууд байхаас гадна 1936 оны хэлмэгдүүлэлтэд өртсөн Цорж ламын хадан сүм, Мөр ламын агуй, Нүдний рашаан, 15 метрийн гүнтэй усан болорын агуй, Ногоон дарь эхийн хунхуй гэх мэт сонин түүх, үзмэртэй билээ.

Энэ газар нутаг байгалийн үүсэл, тогтцоор мөн л өвөрмөц содон. Хаалгын хадны өндөрлөгөөс Их, Бага уулын аль аль нь харагддаг гэж нутгийнхан ярьсгаадаг. Цэлмэг, нартай өдөр Бага газрын чулууны аль нэг оргилоос зүүн хойд зүг хоёр зуу илүү км-т орших Богд хан уулыг харж болно гэж бас ярина. Халхын гурван том уул гэж түүхэнд бичигдсэн нь магадгүй Их, Бага газрын чулуу, Дэлгэрхангайн уул байж мэдэх юм гэсэн таамаглал байдаг ажээ. Чулууны уул эмийн ургамал арвинаараа ихэд алдаршсан бөгөөд янз бүрийн өвчнийг эдгээж илаарьшуулахад хэрэглэдэг төрөл төрлийн зүйл ургамалтай гэсэн ам дамжсан яриа байдаг. Энэ нутгаас ойр холд нэрд гарсан олон сайн оточ, маарамба төрж гарсныг байгалийн энэ хишиг өгөөжтэй холбон хэлэлцэх нь бий.



**Сөдөтийн хоолой:** Баянгийн уулын ар бэлээс хойш баруун, зүүн талаараа өндөр уулсаар хашигдсан, урт хоолой үргэлжилнэ. Энэ хоолойд үзэм шиг бөөрөнхий хүрэн толгой, өндөр шилтэй Сөд хэмээх эмийн ургамал битүү ургасан байдаг тул Сөдөтийн хоолой гэж нэрлэжээ. 1940-өөд оны үед энэ хоолойд эсгий хийж байсан хүмүүс дээр хонины толгойн чинээ том толгойтой могой ирсэнд тэнд байсан мэргэн Дагва гэдэг лам сан тавьж, ном уншин лусыг аргадсанаар могой явчихсан юм гэнэ билээ гэх домгийг нутгийн хөгшчүүд ярьдаг. Мөн Сөдөтийн амны чулуун хавцал дунд ургасан улиасан төгөлийн дунд 300 гаруй жилийн өмнө хоёр лам даяанчлан сууж, тус тусын гэрийг барихдаа уулын бяцхан горхийг гэрийнхээ дундуур урсаж байхаар байрлуулж, гэрээсээ гаралгүй ус авч цай хоолоо зэхдэг байжээ. Лам нарыг өөд болоход нь туурвисан бүтээлүүдтэй нь зэрэгцүүлэн эл хавьд бунхалсан гэдэг яриа бий. Сөдөтийн аманд нэгэн хийдийн туурь байх бөгөөд түүнийг Ловончомбын хийд гэдэг. Хожим эрдэмтэн лам Зава Дамдин хэсэг суун бүтээл туурвиж байжээ.



**Шижир баатрын мөнгөн бөглөөт:** Бага газрын чулууны ууланд Шижир баатрын мөнгөн бөглөөт гэж уул байх агаад уулын орой нь том хадан дээр бөхийсөн хүн сууж буй мэт харагддаг, доороо хөндий агуйтай газар байдаг. Түүхэнд Өндөр гэгээн Занабазар хутагт нутагт

нь их хөл үймээн гарсан тул харьяат албат, шавь, ойр дотныхоо хүмүүсийн хамтаар Бага газрын чулууны ууланд Хүрээний уснаа ирж сууж байсан тухай тэмдэглэсэн байдаг бөгөөд Шижир баатрын морьтойгоо давдаг хөтлийг Шижирийн даваа, харуулд гардаг байсан оргилыг нь Шижир баатрын мөнгөн бөглөөт хэмээн нэрийдсэн тухай домог байдаг.

**Тахилтын агуй:** Тахилгатай хайрхны энгэрт нэлээд дээр газар эрт цагт хүмүүс амьдарч байсан том агуй байдаг. 1900 оны үед очсон хүн богиновтор уургаа агуй руу босгож үзэхэд тулахгүй байсан юм гэнэ билээ гэж ярьдаг. Эдүгээ агуйн нэлээд зайг шувууны сангас, жижиг чулуун овоолго эзэлсэн байдаг.

**Баянгийн агуй:** Баянгийн ууланд хайрхны нэрээр нэрлэсэн нэгэн агуй бий. 1970-аад оны үед геологийнхон буюу Унгарын мэргэжилтнүүд ирж, хаалга үүд хийн, тэсэлгээний зүйлээ хадгалдаг байсан бөгөөд хүн, мал ойртуулдаггүй байв. Харин хөгшид энэ агуйг их эртний агуй хэмээн хуучилдаг байлаа.

**Ганц гэээгтийн сүв:** Баянгийн уулын энгэрт байх энэ хонгилд сайн эрчүүдтэй ганзага нийлдэг, эмэгтэй хүн гэдгээ огт мэддэггүй нэгэн бүсгүй орогнодог байсан гэдэг. Түүний морио оруулдаг байсан газар нь ч энд байжээ. Нэг удаа тэрээр “ловш” Ням гэдэг сайн эртэй бүтэн жил орчим хулгай хийж явж ирээд, “Чи ч сайн нь сайн эр юм аа. Нэг л юм нь муу эр юм” гэж гэнэ. Ням “Миний ер нь юу муу санагдсан юм бол” хэмээн бодож байтал тэрээр мориндоо мордсон хойноо хөхөө гаргаж харуулчихаад тэр чигээрээ зугтаж, гүйцэгдэхгүй алга болон нөгөө агуйдаа ирээд нуугдчихжээ. Үүнээс хойш энэ хонгилыг Ганц гэээгтийн сүв гэж нэрлэх болсон домогтой.

**Санжитын сүв:** 1958 оны үед энэ агуйд эрүүндээ 16 шүдтэй араг яс байсан гэдэг. Тэр үеийн залуучууд дүрсгүйтэн, салчихсан дагзыг нь толгойдоо углаж үзэхэд хамаагүй томдлог байсан гэнэ. Мөн нэлээд сүүлд хүртэл эмээлийн өгөршсөн бүүрэг, хөвөгдсөн өрхний хэсгүүд, монгол гутлын түрийний үлдэгдэл байжээ. Хөгшчүүд “Чулууны ууланд Хавчиг-Тоонотын сүв, Онхын сүв, хар малгайтын сүв зэрэг олон сүв байдаг” хэмээн хуучилдаг билээ.

**Оцон таг:** Хундаганы бууцны зүүн хойно, уулын өндөр орой дээр зөвхөн зүүн талаасаа л ордог, эргэн тойрон эгц ханан хадаар хашигдсан нэгэн том хонхор уулын таг бий. Үүнийг нутгийнхан Оцон таг хэмээн нэрлэдэг. Энд сайн эрчүүд дээр үед холоос хөөж ирсэн олон азарга адуугаа оруулчихаад аман дээр нь сууж байхад адуу хаашаа ч гарч чаддаггүй байсан юм гэнэ билээ.

**Нүдний рашаан:** Сөдөтийн хоолойн баруун бэлд нэгэн хадан дээр гар оруулахад багтдаг, аяганы чинээ амтай, гүнээрээ тохой шахам нүх байдаг ба бороо орсны дараа энэ нүхэн хаданд нүдний рашаан үүсдэг гэлцдэг бөгөөд тэндээс хөгшчүүд рашаан авдаг байжээ.

**Жаргалантын агуй:** Сөдөтийн хоолойн зүүн хойд талын өндөр уулыг Жаргалант хайрхан гэнэ. Энэ уулын энгэрт урт нь 20 метр, дундаа босоо хүний өндөртэй, дотроо хэдэн хонгилтой, мухартаа доош гарсан нүхтэй нэлээд том агуй бий. Энэ нутагт ганц ямаатай хөгшин суудаг байгаад ямаа нь агуй руу ороод алга болж, араас нь орсон эмгэн ч эргэж гарч ирээгүй тул агуйд дахин хүн оруулахгүйн тулд 3 метр орчмын нарийхан хэсэгт таглаж битүү болгосон гэж ярьдаг. Мөн уулын оройд гэр барьж, амьдарч

болохуйц тэгш сайхан талбайтай, уулын таг газар бий. Нутгийнхан энэ газрыг “Шанаган таг” хэмээн нэрлэдэг.



### Хадан сүм

Сөдөтийн хоолойн зүүн урд хаданд “Хадан сүм” гэх их сонин тогтоцтой, улиас, халгай битүү ургасан үзэсгэлэнт нэгэн ам буй. 1960-аад он хүртэл сүм байсан барилгын хана нь бүтэн, доогуураа борооны ус урагш буюу доошоо урсдаг, хөндий чулуун шалтай, өмнө нь хэд хэдэн гэр зассан буурьтай, үүдний хэрэм барилгын хана нь бараг бүтнээрээ байдаг байсан. Харин улиаснуудын хальсан дээр нь он сар өдөр, хүний нэрс бичсэн байдаг. Энэ сүмийн баруун урд хадны энгэрт нэгэн агуй байх бөгөөд энд “Үет мөр лам” гэдэг хүн сууж, нямба хийж, номоо бясалгадаг байж. Сүүлд ойрхон зусдаг айлууд ширүүн борооноор хонио оруулдаг болсноос зузаан өтөг бууцтай болсон гэдэг.



**Ногоон дарь эхийн хунхуй:** Ацын булгаас



баруун хойш Өндөр уулын энгэрт нэлээд дээр газар өглөөний наран мандахад орчиндоо нил ногоон гэрэл цацарч харагддаг нэг том хүнхэр хад бий. Нутгийнхан зулын 25 болгонд тэнд очиж, зул өргөн арц хүж уугиулахад нэлэнхүйдээ оюу номин лугаа их ногоон

цэнхэр гэрэл тунардаг тул нутгийнхан “Ногоон дарь эхийн хунхуй” хэмээн нэрлэжээ.



**Азарган хүрэн:** Бага газрын чулууны ууланд Баянгийн энгэрт зүйн хойд зүг чиглэн давхиж буй ганц адуу шиг хүрэн хад бий. Нутгийнхан энэ хадыг дэргэд нь нэрлэдэггүй бөгөөд бөөгийн онгодтой хэмээн хэлэлцдэг. 2003 онд дэлгэрийн Чойрын хийдэд Энэтхэг гаралтай, Америкт амьдардаг нэгэн том ламтан ирж, Чойжин буугаад “Танай энд, Бага газрын чулууны ууланд бөөгийн онгодтой газар байна” гээд уг хадыг зориуд очиж үзэн ихэд сүсэглэж байлаа. Энэхүү Бага газрын чулууны уул хэмээх сүр жавхлант хадан уулыг зорих гадаад, дотоодын аялагчдын тоо сүүлийн жилүүдэд улам нэмэгдэж байна. Аялал жуулчлалын чиглэлээр 2003 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж буй “Бага газрын чулуу”, “Баянбулаг” жуулчны баазууд

нь жуулчдад үйлчлэн сум, орон нутагт хувь нэмрээ оруулж байна. Уг газар нь анх 1985 онд орон нутгийн тусгай хамгаалалтад, 2012 оны аравдугаар сараас Улсын тусгай хамгаалалтад орсон. Бага газрын чулууны уулын анхны байгаль хамгаалагч Г.Жагзам 1996 он хүртэл ажиллаад, 1996 оноос одоо хүртэл байгаль хамгаалагчаар П.Батсайхан ажиллаж байна. 2010 оноос Бага газрын чулууны уулыг сумын ИТХ-аар хэлэлцэж, сумын Тахилгат уул болгож, уул тахих ёслолыг 6-7 дугаар сарын хооронд зохион байгуулж, хүндтэй таван хайрхнаа тахин шүтдэг. Улаанбаатар хотод ажиллаж, аж төрж буй нутгаа гэх сэтгэлтэй иргэд, залуучууд, орон нутгийн малчидтай хамтран уулын тахилгын ёслолыг гүйцэтгэдэг сайхан уламжлал тогтжээ.

## ЦАХИРЫН ЦЭНХЭР УУЛС

Дэлгэрцогт сумын төвөөс хойш 50 орчим км зайтай орших холоос цэнхэртэн харагдах хос уулыг “Цахирын уулс” гэдэг. Баруун талынхыг нь “Их цахир” /далайн түвшнээс 1434 м өндөр/, зүүн талынхыг нь “Бага цахир” /далайн түвшнээс 1417 м өндөр/ гэнэ. Энэ хавийн нутаг нь хээрийн бүсийн монгол голдуу бэлчээрийн сайхан ургамалтай, өвөл цас арай ахиу унадгийг эс тооцвол жилийн аль ч улиралд мал идээшлэхэд зохистой сайн нутаг гэгддэг. Цахирын уулсын ар хөндий Баянгийн булаг, Дэлгэр нуур, Сумт бор өндөр гээд ёстой л адууны нутаг, толгод хөндий бүхэн нь туурайтны хээгээр тамгалагдсан сайхан газар бий.

Ар өврийн цайдам бэлчээрт нь  
Адуу мал нь тайван идээшилсэн  
Айл саахалтын цагаан өргөөнд нь  
Амраг хайрын дуу эгшиглэсэн  
Аав л, ээжийг минь санагдуулах  
Адилхан нэртэй уулс минь ээ  
Амьдрал үйлсээ даатган сүсэглэх  
Амьдын диваажин Цахирын уулс минь ээ



гэж аймгийн Засаг даргаар ажиллаж байсан уул нутгийн хүргэн Ж.Адъяа уулсаа магтсан, сайхан дуу бичсэн билээ.

Зундаа булгийн уснаас ундаалж, ургамлын соргогийг идсэн адуу уулынхаа ар дээр азарга, азаргаараа багшран зогсох нь ёстой л адууны орон гэлтэй харагддаг. Энэ ууланд хээрийн бүсийн үнэг, мануул, тарвага, зурам, хярс, туулай зэрэг ан амьтдаас гадна аргаль, янгир, чоно хааяа орж ирдэг байна. Мөн олон зүйлийн шувууд, идлэг шонхор хүртэл бий. Дэлгэрцогт уулын хошуунд Дайчин бэйл Мөнх-Очир ноёны үед хангай говийг дамжуулан хазаар гүйлгэдэг, уурга урттай, зартай сайн эр Дарьсүрэн гэдэг хүн энэ уулын энгэрээр нутагладаг байжээ. Тэрээр Монголын говийн уул ус, хаана нь ямар хад чулуу, өвс ногоо байдгийг андахгүй сайн мэддэг, харанхуй шөнө ч гэсэн мориноосоо бууж газрын шороог барьж, имэрч үзээд л явж буй газраа мэддэг, таньдаг байсан гэлцдэг. Цахирын ууланд энэ сайн эрийн бүгдэг байсан агуй, хонож, унтаж хэвтдэг байсан чулуун ор, морины уяа нь ч байдаг гэнэ. Мөн Цахир уулын хавьд Цахирын жас гэж байсны туурь, суварга байсан хөшөөний үлдэгдэл одоо ч байдаг. Энэ

хангайг дээр үеэс нутгийнхан тахидаг байсан бөгөөд нутгийн олон уламжлалаа одоо ч гэсэн хадгалан, морь уралдуулж, бөх барилдуулж, бэсрэг наадам хийж, нутгийн уул ус, лусаа баярлуулсаар байна.

Цахир уул, Цахиурт нутаг ойр тойрондоо төдийгүй нийт монголчуудын түүхэнд тодорхой учир холбогдолтой орон газар юм. Энэ бүс нутагт их эрдэмтэн Зава Дамдин гавж, Богд хаант Монгол Улсын баатар Мөнхийн Дорждэрэм нар мэндэлсэн билээ. Одоо ч гэсэн урлаг соёлын зүтгэлтэд, эрдэмтэн, эмч, багш, малчин, ажилчин гээд нэрд гарсан олон хүн Цахир, Цахиуртаар овоглож явдаг.

Цахиурт нутаг тун саяхан болтол цахиур чулуугаар баян байсан. Тиймдээ ч ийм нэртэй болсон байх. Цахиур нь эрдэнэсийн чулуу биш ч хатуулаг чанараараа байгалийн энэ төрөл дотроо дээд ангилалд багтдаг. Монголчуудын уламжлалт гал гаргах хэрэгсэл - хэтний нэг гол бүрэлдэхүүн хэсэг нь цахиур байдаг. Зориуд бэлтгэж авсан хумсны толион чинээ цахиурыг хэтний ган төмрөөр хэдэнтээ цахих агшинд үрэлтээс үүссэн оч чулуун дээр дэвссэн уул

хэмээн нэрлэдэг хөвсгөр шатамхай эд дээр унаж сая гал үүснэ. Хэтийг монголчууд чүдэнз асаагуур, цахилгаан гүйдэл мэт гал гаргах хэрэгсэл бий болохоос өмнө хэрэглэж ирсэн, эдүгээ хуучин цагийн эд өлгийн нэгэн дурсгал болон үлджээ. Манайхны дээр үеийн цахиур буу ч ялгаагүй энэ чулууны дээрх чанарт түшиглэж бүтээсэн нэгэн төрөл зэвсэг юм. Уншигчдадаа сонирхуулахад цахиур чулууны химийн бүтцэд Менделеевийн үелэх системийн 14 дүгээрт жагсдаг цахиур хэмээх элементийн давхар исэл зонхилдгоос тийнхүү хатуу байдаг юм байна. Цахиур чулууг дээр үеэс шил, шаазан, вааран эдлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглаж ирсэн.

## **ХИЙМОРЬ ХУРАЙЛСАН ДЭЛГЭРЦОГТ ХАЙРХАН**

Сумын төвөөс баруун хойд зүгт 18 км зайд Бага газрын чулууны уулын урд талд зэрэгцээ байрлалтай Дэлгэрцогтын уул гэж хийморь хайрласан, их овоо тахилга бүхий баруунаас зүүн тийш сунаж тогтсон нэгэн уул бий. Нутгийнхан энэ уулыг хоймортоо залсан бурхан лугаа адил тахин шүтэж, биширдэг. Энэ уулыг Довдондорж, Эрэндорж ноёны үед дөрвөн уншлагаар тахиж байсан гэх бөгөөд 1918 оны үед Их номт Зава Дамдин энэ ууланд зориулан шинээр сан, тахилга зохиосон байдаг. Энэ уулан дээрээс 108 уулын орой, 70 булгийн эх үзэгддэг гэсэн домог бий. Ер нь дээхэн үедээ сумын нутаг ус сайтай Хар хадын булаг, Жумбын булаг, Өгөөмөрийн булаг, Ар булаг, Олон шанд, Эмээлт, Үүдийн булаг, Эрэг дэлийн булаг, Зүрхэн худаг, Ухны булаг гэх зэрэг олон булаг, нуур устай, бэлчээр сайтай сайхан газар орон байжээ. Дэлгэрийн ууланд хээрийн голдуу ургамал, буйлс голлон ургана. Нутгийнхан ярихдаа энэ уул их мэдрэмжтэй, тахиж хайрлаж чадвал хур бороо, алив бүхнийг хайрлаж чаддаг

онгон сахиустай, лустай харьцдаг хайрхан гэж ярьдаг. 1985 оны үед Гурвансайхан чигийн хэдэн тууварчин 3000 орчим хонь, ямаа тууварлаж явахдаа энд хоноглохоор болж, хоорондоо “Энэ уул чинь ийм байдаггүйсан, зовхийж цайраад л нэг муухан байх чинь”... гэж ярилцжээ. Гэтэл гэнэт нэг том бөөн хар уул гарч ирснээ тэнгэр тачигнаж, бороо мөндөр холилдон асгарч, нөгөө хонь ямаанууд нь урсчихсан байсан гэж нутгийн тууварчид ам дамжин ярьдаг. Одоо энэ газарт Зава ламын байгуулсан сүм дуган, орон хийдийг шинээр сэргээн, бурхан номын ёс, дэг жаягийг хөгжүүлэн, номын ариун дагшин газар болон цэцэглэж байна. Дээр үеэс нутгийнхан энэ уулаа тахиж, тэнгэр, уул хангай нь бороо хураа хайрлан, дэлхий дэлэгнэсэн сайхан зун болдог ажээ. Энэхүү уламжлал одоо ч хадгалагдан, энэ уулын 13-тын овооны тахилгыг нутгийн уугуул Д.Зүмбэрэллхам, Т.Цэрэнпүрэв нар нутгийн залуучуудтай хамтарч сэргээн жил бүр орон нутгийнхантайгаа нийлж тахидаг болжээ.




## **ЭРДЭНИЙН ЧУЛУУН ШАТАР БУТАРСАН ГАЗАР**

Сумын төвөөс хойд зүгт Их, Бага туулай гэж маш гоё гоё чулуутай нэгэн ухаа бий. Энэ нутагт эрт цагт эрдэнийн чулуун шатар бүтээсэн юм

гэнэ билээ гэх домгийг өвгөд өгүүлдэг. 1923 онд Дэлгэрцогт уулын хошууны Засаг захиргааг энэ ухаагийн баруун дэнжид байгуулж байсан түүхт нутаг хэмээн яригддаг юм байна.

## ЭНЕРГИЙН ТӨВ



Сумын төвөөс хойш 4 орчим км-т “Сэнжит хад” гэж босоо хүн доогуур нь ороод гарч ирж болдог нэгэн нүхтэй хад байдаг. Энэ хадыг “Энергийн төв” хэмээн нэрлэдэг бөгөөд хүний биед эерэг сайн энерги өгдөг, өвчин эмгэгийг илааршуулдаг хэмээн нутгийнхан ярьдаг.

Дэлгэр сайхан нутагт минь домог түүхтэй сонин содон газрууд олон байдгаас өвгөдөөс сонсож, өөрсдөө үзэж харсан цөөнийг нь товчлон тэмдэглэсэн нь энэ буй заа.

